



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

*Баяндун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит*

Аудитын код: **ДОА-2021/1/СТА-ТШЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Чойбалсан хот

2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга

бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: [bolortuulb@audit.gov.mn](mailto:bolortuulb@audit.gov.mn)

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: [semjidmaai@audit.gov.mn](mailto:semjidmaai@audit.gov.mn)

Аудитор: О.Эрдэнэтуяа

Утас: 7000-3775, [khaanconsultingaudit@gmail.com](mailto:khaanconsultingaudit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит



## Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт .....	11
3.4. Материаллаг байдал .....	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	13
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
3.9. Аудитын илрүүлэлт.....	14
Залруулсан алдаа.....	14
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	15
4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	15

## 1.Хараат бус аудиторын дүгнэлт

 <b>ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР</b> <small>21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р байр ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7059-4203</small>	<b>БАЯНДУН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Ш.БАТЖАВ ТАНАА</b>
<i>дод. ол. 24 № 158</i>	
танай _____	-ны № _____ -т
<b>АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ</b>	
<b>Зөрчилгүй дүгнэлт</b>	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баяндун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p>	
<p>Баяндун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.</p>	
<b>Дүгнэлтийн үндэслэл</b>	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p>	
<b>Бусад мэдээлэл</b>	
<p>Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Баяндун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө дүгнэгдээгүй байна.</p>	
<p>Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.</p>	
<b>Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага</b>	
<p>Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.</p>	
<p>Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.</p>	
<b>011021227</b>	

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>142,303,182.10</b>	<b>135,256,086.53</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	124,024.45	630,250.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	124,024.45	630,250.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	142,179,157.65	134,625,836.53
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	142,179,157.65	134,625,836.53
35410	Бичиг хэргийн материал	51,697,281.04	48,163,896.96
35420	Аж ахуйн материал	84,662,376.61	80,049,201.57
35460	Хүнсний материал	269,500.00	862,738.00
35470	Бусад хангамжийн материал	5,550,000.00	5,550,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,082,501,469.87</b>	<b>2,257,926,502.81</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,082,501,469.87	2,257,926,502.81
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,028,593,869.87	2,202,590,231.93
39201	Барилга, байгууламж, орон сууц	756,209,919.77	1,937,928,354.77
39202	Хуримтлагдсан элэгдэл	(25,745,363.45)	(64,978,609.01)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	75,000,000.00	75,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(25,000,000.08)	(37,500,000.12)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	245,891,522.00	302,480,292.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(164,695,403.35)	(175,111,394.70)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	40,755,069.40	53,988,537.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	(22,962,976.46)	(25,225,476.94)
39209	Зам, гүүрийн байгууламж	6,514,115.16	6,514,115.16
39210	Хуримтлагдсан элэгдэл	(98,509.20)	(964,474.68)
39213	Түүх соёл музейн дурсгалт зүйлс	31,950,650.00	31,950,650.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	108,748,272.40	108,019,654.90
39215	Хуримтлагдсан элэгдэл	(19,110,955.63)	(30,648,947.06)
39217	Ном	21,137,529.31	21,137,529.31
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	53,907,600.00	55,336,270.88
39301	Програм хангамж	340,000.00	340,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(340,000.00)	(340,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	53,907,600.00	55,336,270.88
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,224,804,651.97</b>	<b>2,393,182,589.34</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>630,250.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	630,250.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	630,250.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	630,250.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	630,250.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,224,804,651.97</b>	<b>2,392,552,339.34</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,224,804,651.97	2,392,552,339.34
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	434,020,522.80	434,020,522.80
51101	Өмч: - төрийн	434,020,522.80	434,020,522.80
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	162,891,629.36	1,330,639,316.73
51210	Өмнөх үеийн үр дүн	162,891,629.36	162,891,629.36
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,167,747,687.37
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	627,892,499.81	627,892,499.81
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,224,804,651.97</b>	<b>2,393,182,589.34</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>997,864,465.31</b>	<b>2,197,126,373.88</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>216,109,465.31</b>	<b>1,260,617,973.88</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>216,109,465.31</b>	<b>1,260,617,973.88</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	216,109,465.31	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	216,109,465.31	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	1,260,617,973.88
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>781,755,000.00</b>	<b>936,508,400.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>739,655,000.00</b>	<b>888,440,100.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	739,655,000.00	888,440,100.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>-</b>	<b>800,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	800,000.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>42,100,000.00</b>	<b>47,268,300.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	42,100,000.00	47,268,300.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>857,579,182.33</b>	<b>1,028,923,498.39</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>857,579,182.33</b>	<b>1,028,923,498.39</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>827,763,136.28</b>	<b>925,915,234.44</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>577,555,685.83</b>	<b>656,154,925.63</b>
210101	Үндсэн цалин	444,544,084.83	455,405,404.46
210102	Нэмэгдэл	117,354,520.00	160,358,801.53
210104	Урамшуулал	15,657,081.00	40,390,719.64
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>74,223,316.67</b>	<b>82,530,780.57</b>
210201	Тэтгэврийн даатгал	50,464,078.35	55,673,445.76
210202	Тэтгэмжийн даатгал	5,836,595.52	6,903,656.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,023,829.36	5,716,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,095,141.03	1,429,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,803,672.41	12,808,277.93
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>37,274,500.00</b>	<b>44,082,955.30</b>
210301	Гэрэл, цахилгаан	11,576,695.00	11,711,675.30
210302	Түлш, халаалт	25,697,805.00	31,407,280.00
210303	Цэвэр, бохир ус	-	964,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>24,290,031.86</b>	<b>25,169,129.12</b>
210401	Бичиг хэрэг	2,725,150.00	5,310,504.08
210402	Тээвэр, шатахуун	5,663,500.00	2,670,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,948,500.00	1,937,100.00
210404	Ном, хэвлэл	47,100.00	138,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	437,000.00	950,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,468,781.86	14,163,425.04
2105	<b>Нормативт зардал</b>	<b>37,178,581.00</b>	<b>22,776,650.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	287,900.00	1,787,800.00
210502	Хоол, хүнс	36,709,751.00	18,988,850.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	180,930.00	2,000,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,046,450.00</b>	<b>148,750.00</b>
210604	Урсгал засвар	2,046,450.00	148,750.00
2107	<b>Томлолт, зочны зардал</b>	<b>492,600.00</b>	<b>600,000.00</b>
210702	Дотоод албан томлолт	492,600.00	600,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,575,370.00</b>	<b>2,429,750.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,575,370.00	2,249,750.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	180,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>72,126,600.92</b>	<b>92,022,293.82</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,058,880.00	2,244,584.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,807,700.00	5,039,957.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	69,260,020.92	84,737,752.82
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>29,816,046.05</b>	<b>103,008,263.95</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>27,283,824.00</b>	<b>17,989,422.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	26,333,824.00	15,989,422.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	950,000.00	2,000,000.00
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>2,532,222.05</b>	<b>85,018,841.95</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,532,222.05	85,018,841.95
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>140,285,282.98</b>	<b>1,168,202,875.49</b>
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>226,000.38</b>	<b>455,188.12</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	226,000.38	455,188.12
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(226,000.38)</b>	<b>(455,188.12)</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>140,059,282.60</b>	<b>1,167,747,687.37</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>			
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>781,755,000.00</b>	<b>936,508,400.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТНИЙ ОРЛОГО</b>	<b>781,755,000.00</b>	<b>936,508,400.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>739,655,000.00</b>	<b>888,440,100.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	739,655,000.00	888,440,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>-</b>	<b>800,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	800,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>42,100,000.00</b>	<b>47,268,300.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	42,100,000.00	47,268,300.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>781,755,000.00</b>	<b>936,508,400.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>781,755,000.00</b>	<b>936,508,400.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>749,868,349.95</b>	<b>832,906,898.05</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>580,656,900.21</b>	<b>656,154,925.63</b>
210101	Үндсэн цалин	438,924,600.00	455,405,404.46
210102	Нэмэгдэл	81,807,300.00	160,358,801.53
210104	Урамшуулал	59,925,000.21	40,390,719.64
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>71,320,626.74</b>	<b>82,406,756.12</b>
210201	Тэтгэврийн даатгал	49,356,000.00	55,549,421.31
210202	Тэтгэмжийн даатгал	5,740,076.39	6,903,656.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,645,400.00	5,716,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,161,200.00	1,429,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,417,950.35	12,808,277.93
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>38,453,000.00</b>	<b>44,118,955.30</b>
210301	Гэрэл, цахилгаан	11,576,695.00	11,711,675.30
210302	Түлш, халаалт	26,876,305.00	31,407,280.00
210303	Цэвэр, бохир ус	-	1,000,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>10,613,300.00</b>	<b>16,986,570.00</b>
210401	Бичиг хэрэг	668,000.00	1,662,670.00
210402	Тээвэр, шатахуун	4,340,000.00	2,670,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,948,500.00	1,937,100.00
210404	Ном, хэвлэл	388,000.00	570,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	450,000.00	950,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,818,800.00	9,195,900.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>36,617,043.00</b>	<b>22,776,650.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	287,900.00	1,787,800.00
210502	Хоол, хүнс	34,979,147.00	18,988,850.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,349,996.00	2,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,647,000.00</b>	<b>148,750.00</b>
210604	Урсгал засвар	3,647,000.00	148,750.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	<b>492,600.00</b>	<b>600,000.00</b>
210702	Дотоод албан томиллолт	492,600.00	600,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,500,000.00</b>	<b>2,429,750.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,500,000.00	2,249,750.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	180,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5,567,880.00</b>	<b>7,284,541.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,649,980.00	2,244,584.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,917,900.00	5,039,957.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>31,886,650.05</b>	<b>103,601,501.95</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>29,354,428.00</b>	<b>18,582,660.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	28,054,428.00	16,582,660.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,300,000.00	2,000,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>2,532,222.05</b>	<b>85,018,841.95</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,532,222.05	85,018,841.95
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхсийн үлдэгдэл</b>		



## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	434,020,522.80	627,892,499.81	162,891,629.36	1,224,804,651.97
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	434,020,522.80	627,892,499.81	162,891,629.36	1,224,804,651.97
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
C07	Тайланг үеийн үр дүн				-
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	434,020,522.80	627,892,499.81	162,891,629.36	1,224,804,651.97
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	434,020,522.80	627,892,499.81	162,891,629.36	1,224,804,651.97
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	434,020,522.80	627,892,499.81	162,891,629.36	1,224,804,651.97
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
D08	Тайланг үеийн үр дүн			1,167,747,687.37	1,167,747,687.37
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	434,020,522.80	627,892,499.81	1,330,639,316.73	2,392,552,339.34

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	935,708,400.00	850,689,558.05
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	935,708,400.00	850,689,558.05
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	910,858,800.00	832,106,898.05
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	721,168,600.00	656,154,925.63
210101	Үндсэн цалин	482,740,000.00	455,405,404.46
210102	Нэмэгдэл	184,670,900.00	160,358,801.53
210104	Урамшуулал	53,757,700.00	40,390,719.64
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	90,146,100.00	82,406,756.12
210201	Тэтгэврийн даатгал	61,299,400.00	55,549,421.31
210202	Тэтгэмжийн даатгал	5,769,300.00	6,903,656.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,442,300.00	5,716,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	7,211,700.00	1,429,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,423,400.00	12,808,277.93
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	43,921,300.00	44,118,955.30
210301	Гэрэл, цахилгаан	11,513,700.00	11,711,675.30
210302	Түлш, халаалт	31,407,600.00	31,407,280.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,000,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	16,246,000.00	16,186,570.00
210401	Бичиг хэрэг	1,668,000.00	1,662,670.00
210402	Тээвэр, шатахуун	2,670,000.00	2,670,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,948,500.00	1,937,100.00
210404	Ном, хэвлэл	588,000.00	570,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	950,000.00	950,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,421,500.00	8,395,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,421,500.00	8,395,900.00
2105	<b>Нормативт зардал</b>	25,455,700.00	22,776,650.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,787,900.00	1,787,800.00
210502	Хоол, хүнс	21,667,800.00	18,988,850.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.00	2,000,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,347,000.00	148,750.00
210604	Урсгал засвар	3,347,000.00	148,750.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	674,100.00	600,000.00
210702	Дотоод албан томилолт	674,100.00	600,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,610,000.00	2,429,750.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,250,000.00	2,249,750.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	180,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	7,290,000.00	7,284,541.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,250,000.00	2,244,584.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,040,000.00	5,039,957.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	24,849,600.00	18,582,660.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	24,849,600.00	18,582,660.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	22,849,600.00	16,582,660.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	2,000,000.00
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл		
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	935,708,400.00	850,689,558.05
1310	<b>ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	935,708,400.00	850,689,558.05
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	888,440,100.00	803,421,258.05
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	47,268,300.00	47,268,300.00



## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	0.00	800,000.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	0.00	800,000.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙТЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	0.00	800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	800,000.00
210406	Бага үнэгэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	800,000.00
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	0.00	800,000.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	0.00	800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		800,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

### **3.Аудитын тайлан**

#### **3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баяндун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Ш.Батжав танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 15-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Хаан консалтинг аудит ХХК-ийн гэрээт аудитор О.Эрдэнэтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Баяндун сумын Ерөнхий боловсролын сургууль 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 07 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ**

Баяндун сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сургуулийн насны хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих
- Монгол Улсын Боловсролын тухай хууль, төрийн холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан тушаал шийдвэрийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох
- Бүрэн дунд боловсролын зорилго нь мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

#### **3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ**

Баяндун сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баяндун сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 1,029,378.6 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 20,587.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баяндун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,168,377.8 мянган төгрөгөөр буюу 95.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	124.0	630.2	506.2
Урьдчилгаа			
Бараа материал	142,179.2	134,625.8	-7,553.4
Үндсэн хөрөнгө	1,082,501.4	2,257,926.5	1,175,425.1
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,224,804.6</b>	<b>2,393,182.5</b>	<b>1,168,377.9</b>
Өр төлбөр	0	630.2	630.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,224,804.6	2,392,552.3	1,167,747.7
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,224,804.6</b>	<b>2,393,182.5</b>	<b>1,168,377.9</b>

Авлага, өглөгийн данс 630.2 мянган төгрөг байгаа нь Хөгжлийн бэрхшээлтэй 2 албан хаагчаас хувь хүний орлогын албан татвар суутгасан байна.

Бараа материалын данс 134,625.8 мянган төгрөг болж 7,553.4 мянган төгрөгөөр буурсан нь захирлын тушаалаар бараа материал акталснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө данс нь 2,257,926.5 мянган төгрөг болж 1,175,425.1 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалтаар 1,217,190.5 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 43,427.4 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө акталсан 8,377.2 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо данс 2,392,552.3 мянган төгрөг болж 1,167,747.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант хугацааны үр дүнгээс шалтгаалсан.

Баяндун сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,199,261.9.8 мянган төгрөгөөр буюу 126.3 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 171,344.3 мянган төгрөгөөр буюу 20 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, хангамжийн материалын зардал бараа

үйлчилгээний бусад зардлууд байна. Энэ нь цалин нэмэгдсэн, бараа материал зарлагадсан зэргээс шалтгаалсан байна.

### **3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 981,200.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 981,200.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 45,495.2 мянган төгрөгөөр бууруулж 935,704.8 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 935,708.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 888,440.1 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 47,268.3 мянган төгрөгийг орон нутгаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 888,440.1 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 47,268.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 935,708.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 850,689.6 мянган төгрөгийг зарцуулж 85,018.8 мянган төгрөгийг улс, орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 850,689.6 мянган төгрөг буюу 90 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал зардлыг 65,013.6 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэл 7,739.3 мянган төгрөгөөр, урсгал засварын зардлыг 3,347.0 мянган төгрөгөөр, албан томилолтыг 77.1 мянган төгрөгөөр, үдийн цай болон хоолны 8,841.8 мянган төгрөгийг тус тус дутуу зарцуулсан нь Ковид-19 цар тахал гарснаас үүдэн үйл ажиллагаа явуулаагүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 800.0 мянган төгрөгийн дэмжлэг авсан байна.

Үүнээс бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсэд 800.0 мянган төгрөгийг зарцуулжээ.

### **3.7. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээлэл байршуулахаас хугацаандаа оруулсан 129, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 22

гүйлгээний 36,571.5 мянган төгрөгийн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаа хоцроон байршуулсан байна.

### 3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,325.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 112,362.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлагыг 100 хувьтай биелүүлсэн байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,325.0	1	1,325.0	0.0	0.0	100.0
Албан шаардлага	3	112,362.7	3	112,362.7	0.0	0.0	100.0
Нийт дүн	4	113,687.7	4	113,687.7	0.0	0.0	100.0

/мянган.төг/

### 3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **18,044.6** мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 2,058.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 150.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, **15,835.8 мянган төгрөгийн зөрчилд** 2 албан шаардлага хүргүүлээ.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажууллаа. Үүнд:

Биет бус хөрөнгөөр бүртгэсэн 1,428.6 мянган төгрөгийн хөрөнгийг бусад үндсэн хөрөнгөд бүртгэж залруулсан.

Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос нийт 630.2 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутган авсныг авлага, өглөг үүсгэж залруулсан.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар залруулаагүй **15,985.8** мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 150.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос суутган тооцсон 630.2 мянган төгрөгийн, и баримтгүй худалдан авалт 15,205.6 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Түлш, шатах тослох материалын зарцуулалтыг тулган шалгахад жолоочийн тооцооны хуудсыг дутуу бөглөсөн, анхан шатны баримтын бүрдэлт хангалтгүй 150.0 мянган төгрөгийн зөрчилтэй замын хуудас байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3 “Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7.”Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудтай нийцэхгүй санхүүгийн тайлангийн хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.



2. Татварын нэгдсэн цахим хуудас дахь и баримт системд бүртгэлгүй 15,205.6 мянган төгрөгийн худалдан авалт байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь “анхан шатны баримт гэж ....., төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх “Үнэн, зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”- гэсэн заалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг зөрчин хөгжлийн бэрхшээлтэй 2 ажилтны цалингийн орлогоос нийт 630.2 мянган төгрөгийн татвар суутгасан нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх “дараах орлогыг албан татвараас чөлөөлнө”, 22.1.2 дахь “хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого”, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх “хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулж байгаа иргэн, хуулийн этгээдийг хууль тогтоомжийн дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах, ...” гэсэн заалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос татвар суутган тооцсон байна. Үүнийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй анхаарал татахуйц байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

#### Аудитын зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

#### 4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Баяндун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			ДОА-2021/1/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Баяндун сумын Ерөнхий боловсролын сургууль		Мянган төгрөгөөр



№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Жолоочийн тооцооны хуудсыг дутуу бөглөсөн, анхан шатны баримтын бүрдэлт хангалтгүй 150.0 мянган төгрөгийн зөрчилтэй замын хуудас байна	150.0	Төлбөрийн акт тогтоох	Захирал, нягтлан бодогч	Ш.Батжав, Б.Оюунбат
2	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 53 зарлагын 36,571.5 мянган төгрөгийн гүйлгээг байршуулаагүй		Албан шаардлага өгөх	Захирал, нягтлан бодогч	Ш.Батжав, Б.Оюунбат
3	Хөгжлийн бэрхшээлтэй 2 ажилтны цалингийн орлогоос татвар суутган авсан.	630.2	Албан шаардлага өгөх	Захирал, нягтлан бодогч	Ш.Батжав, Б.Оюунбат
4	Татварын нэгдсэн цахим хуудас дахь и баримт системд бүртгэлгүй 15,205.6 мянган төгрөгийн худалдан авалт	15,205.6	Албан шаардлага өгөх	Захирал, нягтлан бодогч	Ш.Батжав, Б.Оюунбат
<b>ДҮН</b>		<b>15,985.8</b>			